

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/12

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 77, 80 дугаар зүйл, ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн дарга П. Батбаяр гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай холбоотойгоор 2023 оны 6 дугаар сарын 7-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн дарга чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор холбогдох хууль, дүрэм, журмын дагуу гишүүний цалин хөлс, урамшууллын тооцоо болон бусад тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г.Сэлэнгэ)-д зөвшөөрсүгэй.
3. ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг шалгаруулж, ТУЗ-ийн дараагийн ээлжит хурлаар танилцуулж, томилуулахыг Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо (О. Одбаяр)-нд даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг хуулийн зөвлөх (Ө. Ашхүү)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



П. БАТБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/13

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг сонгох,
Гүйцэтгэх захирал чөлөөлөх тухай*

ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын 23/13 тоот тогтоол шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн ТУЗ-ийн даргаар Ч. Ганхуягийг сонгосугай.
2. ТУЗ-ийн даргаар Ч. Ганхуяг сонгогдсонтой холбоотойгоор Ч. Ганхуягийг Гүйцэтгэх захирлын албан тушаалаас чөлөөлсүгэй.
3. Гүйцэтгэх захирал чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, гэрээ болон холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу цалин хөлс, ээлжийн амралтын тооцоо болон бусад тооцоог хийхийг Ерөнхий нягтлан бодогч (Г.Сэлэнгэ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



О. ОДБАЯР

2023 он 06 сар 07 өдөр

Дугаар 23/14

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгч томилох тухай*

Компанийн тухай хуулийн 76.1.8, Хөдөлмөрийн тухай хуулийн 47.1, ТУЗ-ийн 2023 оны 6 сарын 7-ны өдрийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр компанийн санхүү эрхэлсэн захирал Б. Золбоог томилсугай.
2. Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн ТУЗ-тэй байгуулах гэрээний нөхцөл, төслийг боловсруулан ТУЗ-д танилцуулж, батлуулахыг Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо (О. Одбаяр)-нд даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, Гүйцэтгэх захирлын өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх, бүртгүүлэхийг хуулийн зөвлөх (Ө.Ашхүү)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ч. ГАНХУЯГ